	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Магадлалтай.
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Магадлалтай.
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх	Тийм	Магадлалтай.

	эсэх		
	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8. Соёл	8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.2. Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7. Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх:

Энэ хэсэгт зохицуулалтын хувилбаруудын Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг шинжилсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх үүргийг хуулиар, хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болохоор заасан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулинд шинээр тусгах “сайн дураар нутаг буцах аян” зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтад нийцэх бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хөндөөгүй, бусад хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээний агуулга, зарчимд нийцнэ.

**ТАВ. ЗОХИЦУУЛАТЫН ХУВИЛБАНУУДЫГ
ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

- Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг
- Зорилгод хүрэх байдал;
 - Зардал, үр өгөөжийн харьцаа;
 - Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
 - Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Дээрх хувилбаруудыг харьцуулан үзэхэд “тэг” хувилбар буюу ямар нэг арга хэмжээг авахгүй байх, одоо байгаа нөхцөл байдлыг хэвээр үлдээх нь гадаадын иргэний талаарх бодлого боловсруулахад ахиц дэвшил гарах боломжийг нэмэгдүүлэхгүй байх, асуудлыг шийдвэрлэхийг зорьсон зорилгод чиглэгдэхгүй байна.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх зэрэг арга хэмжээ буюу тухайлбал, одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд тодорхой арга хэмжээ авч болох ч зорилгод хүрэх боломж хязгаарлагдмал хэвээр байхаар байна.

Захиргааны шийдвэр гаргах аливаа захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргахад хуулиар тусгайлан эрх нь олгогдсон байх, түүний үндсэн дээр нийтээр дагаж мөрдөх нөхцөл бүрддэг. Төв нь байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиг үүрэгтэй тул захиргааны шийдвэр гаргахгүй.

Гадаадын орнуудын туршлагаас харахад виз олгох эрх бүхий байгууллагаас олгосон виз тухайн улсын нутаг дэвсгэрт заавал нэвтрэх эрх олгодоггүй, тухайн цаг үед нь шийдвэрлэх буюу хилийн хяналт шалгалтын явцад дахин авч үзэх шаардлагатай асуудлын нэг гэж үздэг байна.² Иймд дээр дэвшүүлсэн асуудлыг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх нь үр дүнтэй байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын сайн дураар нутаг буцах тогтолцоо нь Хууль зүйн яам (Цагаачлалын алба)-наас хэрэгжүүлдэг бөгөөд хууль бусаар оршин сууж буй гадаадын иргэдийг тодорхой хугацаанд аян хэлбэрээр хамруулан өөрийн хүсэлтээр эх орондоо буцах боломжийг бүрдүүлдэг тогтолцоо юм. Уг тогтолцооны хүрээнд тогтоосон хугацаанд сайн дураараа нутаг буцсан гадаадын иргэнийг торгууль болон хилээр дахин орох хоригоос чөлөөлөх зохицуулалт хэрэгжүүлдэг бөгөөд жилд ихэвчлэн нэгээс хоёр удаа зохион байгуулдаг.

Хууль бусаар оршин сууж байсан гадаадын иргэн сайн дураар буцахдаа хилээр гарах өдөр нисэх онгоцны буудал дахь цагаачлалын албанд мэдүүлэг гаргадаг байсан бол 2019 оны 10 дугаар сараас эхлэн нутаг буцах өдрөөс 3–15 хоногийн өмнө биечлэн болон цахимаар урьдчилан мэдүүлэх журамд шилжсэн³. Мөн 2020 оны 7 дугаар сараас эхлэн хууль бусаар оршин суусан хугацааны

² Бодлогын судалгаа. “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын төсөлд хийх хавсрага судалгаа”, 580 дахь тал.

³ <https://www.immigration.go.kr/immigration/1516/subview.do>

торгуулийг төлсөн тохиолдолд хилээр орох хоригоос чөлөөлөх зохицуулалт мөрдөгдөж эхэлсэн.

Сүүлд уг тогтолцоог 2025 оны 12 дугаар сарын 1-нээс 2026 оны 2 дугаар сарын 28-ны хооронд хэрэгжүүлж, тухайн хугацаанд сайн дураараа нутаг буцсан гадаадын иргэнийг торгууль болон хилээр орох хоригоос бүрэн чөлөөлсөн нь онцлог байв. Харин улсын хилээр зөвшөөрөлгүй нэвтэрсэн, хуурамч бичиг баримт ашигласан, гэмт хэрэг үйлдсэн, албадан гаргах үндэслэлтэй болон тодорхой хугацаанаас хойш хууль бусаар оршин сууж эхэлсэн этгээдэд уг хөнгөлөлт үйлчлэхгүй нэг удаагийн хэлбэрээр зохион байгуулсан⁴.

Сайн дураар нутаг буцах тогтолцоог Цагаачлалын хяналтын тухай хуульд тусгайлан зохицуулаагүй боловч Хууль зүйн сайдад олгосон хилээр орохыг хориглох, торгууль болон шийтгэл ногдуулах, түүнчлэн тодорхой нөхцөлд торгуулиас чөлөөлөх бүрэн эрхэд тулгуурлан хэрэгжүүлдэг. Хуульд зааснаар хууль бусаар оршин суусан этгээдэд эрүүгийн хариуцлага эсхүл торгууль ногдуулах үндэслэлтэй боловч захиргааны журмаар торгуулийн шийтгэлээс чөлөөлөх боломж нээлттэй байдаг тул сайн дураар нутаг буцах тогтолцооны хүрээнд торгууль ногдуулахгүйгээр нутаг буцаах шийдвэр гаргах нь хууль зүйн бүрэн үндэслэлтэй⁵ гэж үздэг.

Бүгд Найрамдах Чех Улс

Бүгд Найрамдах Чех Улсын хувьд сайн дураараа нутаг буцах тухай эрх зүйн зохицуулалтыг Европын Холбооны Зөвлөл болон Европын Парламентаас гаргасан зааврын хүрээнд гадаадын иргэний эрх зүйн байдалтай холбоотой хууль тогтоомжид тусгажээ.

Сайн дураараа нутаг буцах хөтөлбөрийг Дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлэх бөгөөд сайн дураараа нутаг буцаж байгаа нь захиргааны зөрчлийн торгууль төлөхөөс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй. Яам нь сайн дураараа нутаг буцаж иргэдийн буцах зардлыг санхүүжүүлэх, аяллын баримт бичиггүй иргэдийг баримт бичиг авахад туслах бөгөөд ийнхүү буцаж байгаа иргэдийг хуяглан хүргэхгүй. Зарим тохиолдолд эх орондоо эргэж очиж, тэндээ суурьших хүртэл тусламж үзүүлдэг.

Сайн дураараа нутаг буцаж буй иргэд нутаг буцсаны дараа төрөөр төлүүлсэн замын зардлын тодорхой хувийг буцааж төлөх, Чех Улсад байсан өр төлбөрийг барагдуулвал хоригийн хугацааг богиносгож болохыг мөн заажээ.

Америкийн Нэгдсэн Улс

Сайн дураар нутаг буцах буюу Voluntary Departure гэдэг нь албадан гаргах сануулга авахгүйгээр заасан тодорхой хугацаанд өөрийн зардлаар нутаг буцах зохицуулалт юм.

⁴ 2025 년 특별자진출국제도 안내 (2).pdf

⁵ 출입국관리법

- Хэрэг шийдвэрлэхээс өмнөх Сайн дураар нутаг буцах
- Хэрэг шийдвэрлэсний дараа Сайн дураар нутаг буцах

Сайн дураар нутаг буцсан тохиолдолд хувь хүний түүхэнд албадан гаргагдсан талаарх түүх бичигдэхгүй. Албадан гаргагдсан тохиолдолд 10 хүртэлх жилийн хугацаанд орохыг хориглодог бол сайн дураар нутаг буцсан тохиолдолд энэ хугацаа харьцангуй бага. Дахин виз мэдүүлэх боломжтой. Харин тогтоосон хугацаанд сайн дураар нутаг буцаагүй бол торгууль төлөх, дахин виз мэдүүлэх, АНУ-д хүндрэл үүсэх зэрэг асуудал үүсдэг.

Хэрэг шийдвэрлэхээс өмнөх Сайн дураар нутаг буцах (pre-conclusion Voluntary Departure):

- Хэрэг хянан шийдвэрлэхээс өмнө буюу сонсгол хийх өдөр хүсэлтээ илгээх,
- АНУ-д хууль бусаар оршин сууж буй гэдгээ хүлээн зөвшөөрсөн,
- АНУ-д оршин суух зөвшөөрлийн хүсэлтээ цуцлуулахыг зөвшөөрсөн,
- Нутаг буцах хүсэлтэй, зардлаа өөрөө гаргах,
- “Сайн хүн”⁶ гэдгээ харуулах.

Хэрэг шийдвэрлэсний дараа Сайн дураар нутаг буцах (post-conclusion Voluntary Departure):

- Хэрэг хянан шийдвэрлэж, сонсгол хийхээс өмнөх 1 жилийн хугацаанд АНУ-д оршин суусах байх,
- Дор хаяж 500 ам.долларын барьцаа төлөх,
- Нутаг буцах хүсэлтэй, зардлаа өөрөө гаргах,
- Сүүлийн 5 жилийн хугацаанд “Сайн хүн” гэдгээ харуулсан.⁷

Дараах тохиолдолд сайн дураар нутаг буцах хүсэлт өгөх боломжгүй. Үүнд:

1. Онц, ноцтой хүнд гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн,⁸
2. Террорист ажиллагаанд оролцсон,⁹
3. Сайн дураар нутаг буцах хүсэлтэд тавигдах шаардлагыг хангаагүй,¹⁰

⁶ АНУ-ын “Цагаачлал, харьяатын тухай хууль”-ийн 9 дүгээр бүлэгт заасан тодорхойлолтоор ойлгоно.

⁷ U.S. Department of Justice’s Executive Office for Immigration Review (EOIR), Information on Voluntary Departure, Self-Help Guide, Jan,2022.

⁸ АНУ, “Цагаачлал, харьяатын тухай хууль”, 8 U.S.C. § 1227(a)(2)(A)(iii).

<https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-1997-title8/html/USCODE-1997-title8-chap12-subchapII-partIV-sec1229c.htm>

⁹ Мөн түүнд, 8 U.S.C. § 1227(a)(4)(B).

¹⁰ Мөн түүнд, 8 U.S.C. § 1229c(b)(1).

4. АНУ-д хууль бусаар орж ирсэн (виз, оршин суух зөвшөөрөл хуурамаар үйлдсэн, хуурамч баримт бичиг ашигласан, урьд нь албадан гаргагдаж байсан, хууль бусаа хил нэвтэрсэн зэрэг)¹¹

Унгар Улс

Унгарын Сайн дураар буцах ба дахин нийгэмшихэд туслах хөтөлбөр (Hungarian Assisted Voluntary Return and Reintegration- HAVRR) нь Унгар Улсад хууль ёсоор оршин суух эрхгүй болсон гуравдагч орны иргэдийг эх оронд нь сайн дурын, аюулгүй, нэр төртэй байдлаар буцах нөхцөлийг бүрдүүлэх, мөн тэднийг эх орондоо тогтвортой дахин нийгэмшихэд дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой.

Энэхүү хөтөлбөрийг Унгар Улсын Дотоод хэргийн яам, Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (IOM)-ын Унгар дахь салбар, Европын Холбооны Орогнол, шилжилт хөдөлгөөн, дахин нийгэмшүүлэх сан (AMIF) хамтран хэрэгжүүлж, санхүүжүүлдэг.

Олон улсын Шилжилт хөдөлгөөний байгууллага нь Унгарт 1993 оноос үйл ажиллагаа явуулж, өнөөг хүртэл 8,000 гаруй иргэнийг эх оронд нь буцахад дэмжлэг үзүүлжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах байгууллагуудтай уялдаа холбоотой ажилладаг. Үүнд:

- Гадаадын иргэдийн бодлого зохицуулах ерөнхий газар (National Directorate-General for Aliens Policing)
- Үндэсний Цагдаагийн Ерөнхий газар (The National Police)
- Будапешт хотын Засаг даргын тамгын газрын Хүүхэд хамгааллын хэлтэс (Government Office of the Capital City Budapest)
- Шилжин ирэгсдэд тусламж үзүүлдэг төрийн бус байгууллагууд¹²

Энэхүү хөтөлбөрт орогнол хүсэгчид, түр хамгаалалтад хамрагдсан иргэд, Унгарт оршин суух нөхцөлийг хангахгүй болсон гуравдагч орны иргэд хамрагдах боломжтой.

¹¹ Мөн түүнд, 8 U.S.C. § 1101(a)(13)(A).

¹² <https://hungary.iom.int/hungarian-voluntary-return-reintegration-and-information-programme-mmia-3219-2020-00001-rr0208#:~:text=The%20Hungarian%20Assisted%20Voluntary%20Return%2C%20Reintegration%2C%20and.cost%20of%20the%20project%20is%20HUF%20323%2C901%2C084.>

HAVRR хөтөлбөр нь дараах хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

1. Буцах ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг: Буцах үйл явцыг бүхэлд нь зохион байгуулж, дараах практик дэмжлэгийг үзүүлдэг. Үүнд:

- Аяллын бичиг баримт бүрдүүлэх,
- Тээврийн хэрэгслийн тасалбар худалдан авах,
- Явах, дамжин өнгөрөх болон очих үеийн зохион байгуулалт, дэмжлэг.

2. Дахин нийгэмших бүрэлдэхүүн хэсэг: Эх орондоо буцсаны дараа амьдралаа тогтвортой үргэлжлүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг үзүүлнэ. Үүнд:

- Ажил, амьжиргаагаа шинээр эхлүүлэхэд туслах,
- Орлого олох боломж бүрдүүлэх,
- Нийгэм, боловсролын үйлчилгээ, дэмжлэгт хамруулах.

HAVRR хөтөлбөр нь өмнөх сайн дурын буцах санаачилгууд дээр тулгуурлан, Унгар улсад энэхүү үйл ажиллагааг тасралтгүй, тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилготой.¹³

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах тандан судалгааны тайланд дэвшүүлсэн дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа, үр нөлөө, үр дүнг нэгтгэн дүгнэхэд, гадаадын иргэдтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн чиг хандлага, олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, төрийн бодлого, хүний эрхэд ээлтэй, зөв зохистой, үр ашигтай тогтолцоонд шилжүүлэх бодит шаардлагаас урган гарч байна.

“Сайн дураар нутаг буцах аян” гэсэн зохицуулалтыг хуульчлан тусгах нь хууль бусаар оршин сууж буй гадаадын иргэдийг албадан гаргах арга хэмжээнээс илүү нийгэм, хүний эрхийг дээдэлсэн, төсвийн зардлыг бууруулсан, олон улсын сайн туршлагад нийцсэн зохицуулалт болохыг харуулж байгаа бөгөөд хууль бус шилжилт хөдөлгөөнийг бууруулах, дотоодын хөдөлмөрийн зах зээлийг хамгаалах, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх бодит суурь болж чадах юм.

Иймд Монгол Улсын нутаг дэвсгэрт хариуцлага оногдуулах зөрчлийг зөвхөн хуулиар шийдвэрлэх зохицуулалттай бөгөөд сайн дураар нутаг буцах явдлыг дэмжиж, тухайн гадаадын иргэнд оногдуулах шийтгэлийг хөнгөрүүлж байгаа учраас

¹³ <https://hungary.iom.int/hungarian-assisted-voluntary-return-and-reintegration-programme-havrr-2013-2014#:~:text=Summary:%20The%20purpose%20of%20the%20voluntary%20return%20initiatives%20within%20Hungary.>

тусгайлсан (Зөрчлийн тухайд хуульд) хөнгөрүүлэх асуудлыг зайлшгүй хуулиар зохицуулах шаардлагатай байна.

---oOo---

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН¹

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улс нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдөн ардчилсан шинэ үндсэн хуулиа 1992 онд баталсны дараагаар бусад хууль, эрх зүйг шинэчлэх эх давалгаа явагдсан бөгөөд үүний нэг нь гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух харилцаа болон тэдний эрх үүргийг тогтоосон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг 1993 онд анх баталсан байна.

2010 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд гадаадын иргэний эрх зүйн байдлыг тодорхойлох, Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суухтай холбогдсон харилцааг зохицуулах үндсэн зорилготой хууль юм.

Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс 15 жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд уг хугацаанд хууль хэрэгжих явцад гарсан бодит үр дагавар, хэрэгжилтийн бодит байдал, практикт тулгамдаж буй асуудал, хуулийн зорилгод хүрсэн түвшинг тодорхойлох, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох, олон улсын чиг хандлага, технологийн хөгжилтэй бодлогын түвшинд уялдуулах зүй ёсны хэрэгцээтэй болж байна.

Өнөөгийн даяаршлын эрин зуунд улс орнуудын хил хязгаар улам нээлттэй болж, хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэхийн хэрээр гадаадын иргэдийн эрх зүйн байдал, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, соёлын дасан зохицол, нийгмийн интеграци зэрэг олон асуудлууд урган гарч байна. Монгол Улс ч үүнээс ангид орших боломжгүй бөгөөд бид бодлогын зөв гарц, цаг үеийн нөхцөл байдалд нийцсэн ухаалаг шийдлүүдийг хамтдаа эрэлхийлэх шаардлагатай.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д тухайн хуулийн нийт заалтын 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орсон бол хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна гэж заасны дагуу Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судлах аргачлалын 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ:

Гадаадын иргэн, харьяатын газар үйл ажиллагаагаа судалгаа, шинжилгээнд тулгуурлан явуулдаг, бодлого боловсруулдаг байгууллага болон хөгжих нь томоохон зорилго байх ёстой. Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын дэмжлэгээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвтэй хамтран “Гадаадын иргэн,

¹ Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийг амжилттай хэрэгжүүлсэн.

Мөн Монгол Улсын хилийн хяналтын байгууллагуудын сургалт, судалгааны талаар хууль тогтоомжид хэрхэн тусгасан талаар авч үзэхэд:

- Хилийн тухай хуульд 34.1-д Улсын хил хамгаалах байгууллагын үндсэн хүч хэрэгсэл нь хилийн цэрэг байх бөгөөд хилийн цэрэг нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай хилийн цэргийн штаб, анги, салбар, зэвсэглэл, техник, ар тал, хангалт, эмнэлэг, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжтэй байна гэж заасан байна.
- Гаалийн тухай хуульд 267¹.5-д Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дэргэдээ эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, гаалийн ажилтан бэлтгэх, давтан сургах чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага, гаалийн лаборатори, хэвлэх үйлдвэр, мэдээлэл-тооцооллын төв, хөрөнгө оруулалт, хангамж үйлчилгээний газар, эрэлч нохойн албыг байгуулан ажиллуулж болно.

Иймд Гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллага нь гадаадын иргэдийг Монголын соёлд сургах, дотоодын иргэдийг зөв мэдээллээр хангах, бодлого боловсруулах, судалгаа, шинжилгээний төвтэй байх шаардлага үүсээд байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Иргэд, аж ахуйн нэгж	<p>Даяарчлалын үед Монгол Улсыг зорих гадаадын иргэд нэмэгдэхийн хэрээр иргэд, аж ахуйн нэгж гадаадын иргэдтэй хөл нийлүүлэн олон талт соёлд уусаж хөгжих нь хязгаарлагдмал, гадаадын иргэд ч Монгол соёл ахуйтай дасан зохицох, даяаршихад сөргөөр нөлөөлж байна.</p> <p>Иймд олон улсын жишигт нийцүүлэн бодлогын судалгааны төвтэй байснаар олон талт хөтөлбөрийг бодлогоор хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.</p>
2	Төр, төрийн албан хаагчид	<p>Гадаадын иргэний талаарх бодлого, судалгаа шинжилгээний мэдээллийн сан бүрдээгүй, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр өгөөжийн тоон үзүүлэлтийг бодит тооцоолох боломж бүрдээгүй, гадаадын иргэдэд үндэсний хууль тогтоомжийг сурталчилан таниулах, зөвлөгөө мэдээллээр хангах, дасан зохицох хөтөлбөр байхгүй зэрэг нь бодлого тодорхойлоход сөргөөр нөлөөлж байна.</p> <p>Иймд бодлогын судалгааны төвтэй болсноор мэдээллийн сан бүрдэж, эдийн засгийн үр нөлөөг бодлогод тулгуурлан төлөвлөх, гадаадын иргэний дасан зохицох олон талт нийгмийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлснээр олон улсын чиг</p>

		хандлагатай хөл нийлүүлэн, бодлогын түвшинд хөгжих ач холбогдолтой гэж үзэж байна.
--	--	--

1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан нөхцөл:

Өнөөгийн даяаршлын эрин зуунд улс орнуудын хил хязгаар улам нээлттэй болж, хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэхийн хэрээр гадаадын иргэдийн эрх зүйн байдал, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, соёлын дасан зохицол, нийгмийн интеграци зэрэг олон асуудлууд урган гарч байна.

Иймд Монгол Улсын тухайд ч дотоодын болон олон улсын чиг хандлагад уялдуулан судалгаа, шинжилгээний ажил, хүний эрх болон гадаадын иргэний талаарх эдийн засаг, нийгмийн оролцоог хангах бодлогыг тодорхойлж гадаадын иргэний эрх зүйн байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, үр дүнд тулгуурлан бодлогын болон үйл ажиллагааны санал, дүгнэлт боловсруулах үндсэн чиг үүрэг бүхий байгууллагын дэргэдэх “Бодлогын судалгаа, шинжилгээний төв”-тэй байх шаардлагатай гэж үзэж байна.

ХОЁР. АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор бодлогын судалгааны төвтэй болсноор мэдээллийн сан бүрдэж, эдийн засгийн үр нөлөөг бодлогод тулгуурлан төлөвлөх, гадаадын иргэний дасан зохицох олон талт нийгмийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлснээр олон улсын чиг хандлагатай хөл нийлүүлэн, бодлогын түвшинд хөгжих ач холбогдолтой гэж үзэж байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хоёрдугаар хэсэгт заасан зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
“Тэг” хувилбар	Асуудал шийдвэрлэгдэхгүй	зорилгод хүрэх боломжгүй
Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	зорилгод хүрэх боломжгүй
Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	зорилгод хүрэх боломжгүй

Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	зорилгод хүрэх боломжгүй
Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	зорилгод хүрэх боломжгүй
Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах эрхийг хуулиар тусгайлан олгосон байхыг шаардах тул боломжгүй	зорилгод хүрэх боломжгүй
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хуульд тусгайлан нэмж тусгасны үндсэн дээр шийдвэрлэгдэх боломж бүрдэнэ.	Үр дүнтэй

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх шатанд сонгон авсан хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Өөрчлөлтөд хамаарахгүй түл ямар нэг нөлөө үзүүлэхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Өөрчлөлтөд хамаарахгүй түл ямар нэг нөлөө үзүүлэхгүй.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Хүний эрхийн асуудлыг хөндөхгүй.
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг,цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Өөрчлөлтөд хамаарахгүй түл ямар нэг нөлөө үзүүлэхгүй.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэд ийг тодорхойлсон эсэх	Тийм	Монгол Улсад ирсэн гадаадын иргэдэд хамааралтай.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		

	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Өөрчлөлтийг хийснээр тодорхой хэмжээний дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Үгүй	Зөвлөмжийн дагуу судалгаа хийх боломжтой.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй	Зөвхөн судалгаа, шинжилгээ хийнэ.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Үгүй	Зөвхөн судалгаа, шинжилгээ хийнэ.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	Хязгаарлалт тогтоохгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Үгүй	Зөвхөн судалгаа, шинжилгээ хийнэ.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	Зөвхөн судалгаа, шинжилгээ хийнэ.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Үгүй	Зөвхөн судалгаа, шинжилгээ хийнэ.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй	Зөвхөн судалгаа, шинжилгээ хийнэ.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Үгүй	Зөвхөн судалгаа, шинжилгээ хийнэ.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Үгүй	Тусгаагүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөөс санхүүжүүлэх боломжтой.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Дотоодын нөөц бололцоонд тулгуурлана.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсоход хүргэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий	Тийм	Дотоодын нөөц бололцоонд тулгуурлана.

зардлын ачаалал	болгох эсэх		
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Гаргах магадлалтай.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Гаргах магадлалтай.
	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Хуульд зохицуулалт орсоноор шинэ ажлын байр үүсэх магадлалтай.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Тодорхой нөлөө үзүүлэх магадлалтай.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх	Тийм	Хуульд зохицуулалт орсоноор байгууллагын бүтцийн өөрчлөлтөд нөлөөлөх магадлалтай.

	шаардлага тавигдах эсэх		
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Харилцааг хуульчилснаар төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох магадлалтай.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1. Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	
	1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх болон тогтвортой байдал	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	
	2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	
	2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Үгүй	
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	
	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	гэх мэт		
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3. Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Үгүй	
	6.2. Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	
7. Гэмт хэрэг, нийгмийн	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх	Үгүй	

аюулгүй байдал	эсэх		
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8. Соёл	8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	8.2. Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	
	8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	

5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7. Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх:

Энэ хэсэгт зохицуулалтын хувилбаруудын Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг шинжилсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх үүргийг хуулиар, хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болохоор заасан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулинд шинээр тусгах “бодлогын судалгаа, шинжилгээний төв”, “сайн дураар нутаг буцах аян”, “гадаад зорчигчийг улсын хилээр шалган нэвтрүүлэх” зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтад нийцэх бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хөндөөгүй, бусад хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээний агуулга, зарчимд нийцнэ.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Дээрх хувилбаруудыг харьцуулан үзэхэд “тэг” хувилбар буюу ямар нэг арга хэмжээг авахгүй байх, одоо байгаа нөхцөл байдлыг хэвээр үлдээх нь гадаадын иргэний талаарх бодлого боловсруулахад ахиц дэвшил гарах боломжийг

нэмэгдүүлэхгүй байх, асуудлыг шийдвэрлэхийг зорьсон зорилгод чиглэгдэхгүй байна.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх зэрэг арга хэмжээ буюу тухайлбал, одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд тодорхой арга хэмжээ авч болох ч зорилгод хүрэх боломж хязгаарлагдмал хэвээр байхаар байна.

Захиргааны шийдвэр гаргах аливаа захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргахад хуулиар тусгайлан эрх нь олгогдсон байх, түүний үндсэн дээр нийтээр дагаж мөрдөх нөхцөл бүрддэг. Төв нь байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиг үүрэгтэй тул захиргааны шийдвэр гаргахгүй.

Бодлогын судалгаа, шинжилгээний төв нь дотоодын болон олон улсын чиг хандлага, судалгаа, шинжилгээ явуулах, гадаадын иргэний талаарх бодлогыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиг үүрэгтэй байгууллагын дэргэдэх, хараат бусаар ажиллах төв юм. Иймд дээр дэвшүүлсэн асуудлыг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх нь үр дүнтэй байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Бүгд Найрамдах Солонгос Улс

Шилжилт хөдөлгөөний сургалт, судалгааны төв (MRTC) нь БНСУ-ын шилжилт хөдөлгөөний талаар эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт эрхэлдэг цорын ганц байгууллага бөгөөд тус төвийг байгуулах талаар хэлэлцээрийг БНСУ-ын Гадаад харилцааны яам болон Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (IOM) 2008 онд байгуулан, 2009 онд хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор мөн оны 12 дугаар сард тус төв үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Сургалтыг дөрвөн чиглэлд хийдэг бөгөөд үүнд:

1. БНСУ-д шилжин суурьшсан гадаадын иргэдэд;
2. Шилжилт хөдөлгөөний талаар бодлого боловсруулах, дадлага олгох сургалтыг БНСУ-ын Засгийн газрын байгууллагууд болон орон нутгийн засаг захиргаануудад;
3. Шилжилт хөдөлгөөний талаар судалгаа, судалгааны ажил хийж буй оюутнуудад;
4. Шилжилт хөдөлгөөний талаар үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдэд зэрэг болно. ²

² Гадаадын иргэн, харьяатын газар, БНСУ-ын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвтэй байгуулах “Эрмэлзлийн бичиг”-ийн тухай танилцуулга, 2023 он.

2007 онд батлагдсан "БНСУ-д оршин сууж буй гадаадын иргэдтэй харилцах тухай суурь хууль"-ийн 5 дүгээр бүлгийн 22-2 дугаар зүйлд тус төвийн эрх зүйн байдлыг ийнхүү тодорхойлжээ.³

Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төв (цаашид "MRTC" гэх)-г БНСУ-ын Засгийн газар болон Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын хооронд байгуулсан ОУШХБ-ын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвийг байгуулах, ажиллуулах тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг дэмжих мөн мэргэшсэн, системтэй шилжилт хөдөлгөөний бодлогыг боловсруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээг дэмжих зорилгоор байгуулна.

Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төв нь хуулийн этгээд байна.

Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төв нь дараах үйл ажиллагаа явуулна. Үүнд:

1. Олон улсын шилжилт хөдөлгөөний бодлого, хууль тогтоомжийн талаарх судалгаа, сургалт, зөвлөх үйлчилгээ, мэдээлэл солилцох,
2. Шилжилт хөдөлгөөний бодлого шинжээчийг сургах,
3. Олон улсын шилжилт хөдөлгөөний бодлогын талаарх олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах, зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, олон улсад хамтран ажиллах,
4. Олон улсын шилжилт хөдөлгөөний бодлоготой холбоотой эрдэм шинжилгээ болон олон нийтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,
5. Олон улсын шилжилт хөдөлгөөний бодлоготой холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны ажил, өгүүлэл тайлан хэвлэх, олон нийтийн хүртээл болгох,
6. Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвийн үүсгэн байгуулагдсан зорилгод хүрэх бусад шаардлагатай үйл ажиллагаа

Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төв нь дүрмийн дагуу гүйцэтгэх удирдлага болон шаардлагатай ажилтантай байна.

Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулийн хуулийн этгээдэд холбогдох зохицуулалтыг Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвд хэрэглэнэ.

Улс нь төсвийн хүрээнд төвийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэж болно.

Судалгааны төвтэй болсноор гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөн, зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллийг системтэйгээр судлан дүн шинжилгээ хийх, бодлого, шийдвэрийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой төлөвлөх, улмаар хил, шилжилт хөдөлгөөний удирдлага, хяналтын үр нөлөөг бодитоор сайжруулах эерэг үр дүнтэй.

Америкийн Нэгдсэн Улс

Дотоодын аюулгүй байдлын яам (DHS)-ны Цагаачлалын Шинжилгээний Төв (Migration Analysis Center) нь Дотоодын аюулгүй байдлын статистикийн алба

³ БНСУ, Хууль зүйн судалгааны хүрээлэн, "БНСУ-д оршин сууж буй гадаадын иргэдтэй харилцах тухай суурь хууль", 2007 он.

(OHSS)-ын харьяа судалгааны гол нэгж юм. Тус төв нь АНУ-ын цагаачлал, шилжилт хөдөлгөөний талаарх судалгааг голчлон гүйцэтгэдэг.

Үндсэн зорилго бол шилжилт хөдөлгөөний урсгал болон цагаачлалын бодлогыг цогцоор нь судлах, шилжилт хөдөлгөөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох, АНУ дахь цагаачлалын нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүн ам зүйн нөлөөг судлана. Дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Судлагдахууныг тодорхойлох,
- Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх,
- Судалгааны загвар, аргачлал боловсруулах,
- Загваруудыг хөгжүүлэх, баталгаажуулах,
- Судалгааны тайлан, илтгэл бэлтгэх,
- Эрдэм шинжилгээний хянан магадлал (peer review) хийх,
- Олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх.

2025 оны (FY 2025) Судалгааны тэргүүлэх чиглэлүүд:

- Дотоодын аюулгүй байдлын яамны Баруун өмнөд хилийн бүс дэх баривчилгааны тоог урьдчилан таамаглах,
- Цагаачлалын төсөв, үйл ажиллагааны төлөвлөлтийг дэмжих зорилгоор дараагийн шатны хэрэгжилтийн дамжлагын (throughput) загвар боловсруулах,
- Хууль бус шилжилт хөдөлгөөнийг өдөөж болон сааруулж буй хүчин зүйлсийг шинжлэх,
- АНУ-д ирсний дараах цагаач болон түр оршин суугчдын (nonimmigrant) дэмжих арга хэмжээг тодорхойлох,
- Одоо ашиглаж буй хүн амын тооцооллыг сайжруулах,
- Хамгаалалтгүй, асран хамгаалагчгүй гадаадын хүүхдүүдийн (UAC) цагаачлалын хүчин зүйлсийг судлах,
- АНУ-ын Баруун өмнөд хил дээр баригдсан гадаад иргэдийн цагаачлалын үр дүнгийн талаар иж бүрэн тайлан гаргах,
- АНУ-ын Баруун өмнөд хил дээр баригдсан орогнол хүсэгчдийн цагаачлалын үр дүнгийн талаар иж бүрэн тайлан боловсруулах зэрэг болно.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Дотоодын аюулгүй байдлын статистикийн алба нь төрийн бус байгууллага, судалгааны төв, бодлогын байгууллагуудад ажилладаг цагаачлалын судлаачидтай хамтран ажилладаг. Харилцаа холбоог бэхжүүлэх зорилгоор Төвийн ажилтнууд:

- Судалгааны үр дүнг эрдэм шинжилгээний, төрийн болон салбарын хурал, чуулгануудад танилцуулах,
- Тогтмол оролцогч талуудтай уулзалт зохион байгуулах,
- Тайлан, судалгаанд зориулсан тогтмол хянан магадлалын (peer review) тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна.⁴

⁴ <https://ohss.dhs.gov/about/migration-analysis-center>

Бүтэц зохион байгуулалтын хувьд Судалгаа, дүн шинжилгээ, Дата, аргачлал, Бодлогыг дэмжих, олон нийтэд сурталчлах, Хөтөлбөр хэрэгжүүлэх, захиргаа гэсэн 4 үндсэн хэлтэстэй.

Жил бүр АНУ-ын Конгрессоос Дотоодын аюулгүй байдлын статистикийн албаны төсвийг баталдаг. Үүсгэн байгуулагдсан эрх зүйн баримт бичиг нь 2002 оны Дотоодын аюулгүй байдлын тухай хууль бөгөөд уг хуулиар яамны бүтэц, зохион байгуулалтыг баталжээ.⁵

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах тандан судалгааны тайланд дэвшүүлсэн дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа, үр нөлөө, үр дүнг нэгтгэн дүгнэхэд, гадаадын иргэдтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн чиг хандлага, олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, төрийн бодлого, хүний эрхэд ээлтэй, зөв зохистой, үр ашигтай тогтолцоонд шилжүүлэх бодит шаардлагаас урган гарч байна.

Бодлогын судалгаа, шинжилгээний төвийг байгууллагын дэргэд, хараат бусаар ажиллуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь гадаадын иргэний талаарх бодлого боловсруулах, гадаад шилжилт хөдөлгөөний бодлогыг зөв зохистой зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, олон улсын чиг хандлагад дүн шинжилгээ хийх, чадавхыг бэхжүүлэх чухал ач холбогдолтой бөгөөд гадаадын зарим орны туршлагаас харахад энэ төрлийн төв нь шилжилт хөдөлгөөний бодлогын тогтвортой, үр дүнтэй хэрэгжилтийг хангах чухал механизм болдог байна.

----oOo----

⁵ АНУ, “Дотоодын аюулгүй байдлын тухай хууль”, 2002 он.
<https://web.archive.org/web/20100527195312/http://olpa.od.nih.gov/legislation/107/publiclaws/hmlndsecty.asp>